

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2020 оны I улирлын/**

2020 оны 03 дугаар сарын 30

Улаанбаатар хот

1. Тус газарт 2020 оны I улирлын байдлаар нийт 3 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байна. 2019 оны I улирлын байдалтай харьцуулахад өргөдөл, гомдол 2,3 дахин бага байна.

Үзүүлэлт	2020.01.01-03.30		2019.01.01-03.30	
	Тоо	Шийдвэрлэлтийн хувь	Тоо	Шийдвэрлэлтийн хувь
Ирсэн өргөдлийн тоо	3	100%	7	100%

2. Нийт ирсэн 3 өргөдлийг 3-н албан хаагч хугацаанд нь 100% шийдвэрлэсэн. Газрын дарга болон Захиргааны хэлтсийн даргад өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар сар тутамд тайлан гарган танилцуулан ажиллаж байна. Энэ хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.

3. Тус газарт 1800-1200 тусгай дугаарын утаснаас 1 өргөдөл, Засгийн газрын 11-11 төвөөс гомдол ирээгүй, ННЗБ бүртгэсэн 1 өргөдөл, гомдол, тус газрын албан хаагчид буюу боловсон хүчинтэй холбоотой өргөдөл, НҮНТ бүртгэсэн 1 өргөдөл, гомдлыг тус тус бүртгэв.

4. Иргэдээс амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдол ирснийг хуулинд заасан хугацаанд журмын дагуу шийдвэрлэн тус албан байгууллагад мэдэгдэл, иргэнд шийдвэрлэлтийн байдлыг албан бичгээр болон утасаар хүргүүлэв.

5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног 23 хоног 6 цаг 40 минут байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар тухай бүр газрын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр өргөдөл гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлж байна

6. Өргөдөл, гомдлын тоон тайланг хавсаргав.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



С.БАТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Т.ТУУЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

/2020 оны I улирал/

2020 оны 03 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Тус газарт 2020 оны I улиралд ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээ

Д/д	Иргэн	Шийдвэрлэлтийн байдал
1	Б.Сэржмядаг	2020 оны 02 сарын 03-ний өдөр Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 01/44 тоот албан бичгээр зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах Дэвжих жигүүр ХХК-ийн Ландыш дэн буудлын үйл ажиллагаанд хяналт тавин, хуулийн дагуу арга хэмжээ аван хамтарч ажиллахыг хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Хариу албан бичигт зөрчлийн хэрэг нээн шалгаж байгаа болон мөн авсан шийтгэлийн хуудсыг хавсарган ирүүлсэн. Гомдол гаргасан иргэн Сэржмядагтай 94112957 утсаар 2020 оны 02 сарын 17-ний өдрийн 10 цаг 20 минутад холбогдон өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, авсан арга хэмжээний талаар мэдэгдэж танилцуулав.
2	Б.Үржинханд	Б.Үржинхандын өөрийнх нь бичгээр гаргасан хүсэлтийн дагуу газрын даргын 2020 оны Б/01 тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөв.
3	Б.Дэнсмаа	Хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож НИТХ-ийн 120 дугаар тогтоолын дагуу танилцуулан мөн Стандарт шаардлага хангахгүй байгаа аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөл олгохгүй зөрчилтэй аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авч ажиллаж байгаа тухай Иргэн Дэнсмаад мэдэгдсэн болно. 2019.12.30 16:14 минут

-ооОоо-